

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ БОЛЖ ӨРГӨЖСӨН НЬ (2006 оноос)

4.1. Улсын хавдар судлалын төв Хавдар судлалын үндэсний төв болсон нь

Эрүүл мэндийн сайдын 2006 оны 12-р сарын 12-ны өдрийн 407 тоот тушаалаар Хавдар судлалын төвийн нэрийг Хавдар судлалын үндэсний төв болгож Эрүүл мэндийн сайдын 2007 оны 5-р сарын 23-ны өдрийн 137 тоот тушаалаар Хавдар судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийг баталжээ.

Улмаар үйл ажиллагааны цар хүрээ өргөжин, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн юм. Үүнтэй холбоотойгоор, орчин цагийн олон улсын жишгийн дагуу клиникийн бүтцийг үүсгэн, 2007 оноос элэг цөс, нойр булчирхайн мэс заслын тасаг, ангиографийн эмчилгээний хэсэг, хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний алба, хавдар судлалын, хөнгөвчлөх эмчилгээний кабинетуудыг шинээр бий болгон, дурангийн кабинетын тоо болон өдрийн хими эмчилгээний орны тоог нэмэгдүүлж, цахим эмнэлгийн тогтолцоонд үе шаттайгаар шилжих ажлыг эхлүүлсэн. Мөн мэргэжлийн сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, хоолны технологич, хоол зүйчийг ажиллуулж эхэлсэн. Энэ бүхэн нь үйлчлүүлэгсдийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа ба эцсийн дүндээ хавдрын тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай байдлаар хүргэх тал дээр дорвитой ажлууд хийгдэж, бодит үр дүнд хүрсээр байна.

Засгийн газрын 2009 оны 8-р сарын 18-ны өдрийн 254 тоот тогтоолоор Хавдар судлалын үндэсний төвийг хүний гавъяат эмч Намхай-Очирын Нямдаваагийн нэрэмжит болгожээ.

Одоогийн байдлаар, Хавдар судлалын үндэсний төв нь 9 алба, 10 тасагтай бөгөөд нийт 381 ажиллагсадтай (эмч 95, сувилагч 115, инженер, техникч, лаборант, эм найруулагч, үйлчлэгч, санхүүгийн ажилтан зэрэг бусад мэргэжлийн 171), 206 ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2007 оноос техник технологийн шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр тус төв нь дижитал рентген, маммографи, дижитал болон өнгөт доплер хэт авиа, ходоод улаан хоолой, цагаан мөгөөрсөн хоолой-уушигны болон хамар-залгиурын дижитал уян дуран, патологийн шинжилгээний дижитал микроскоп, клиник лабораторийн болон иммунологийн автомат анализаторууд зэрэг оношлогооны, туяа эмчилгээний 3 хэмжээст төлөвлөлтийн систем, компьютерт томографи, СО-60 үүсгүүртэй зайн болон дотуур туяа эмчилгээний аппарат, өндөр давтамжит радио долгионоор шарах эмчилгээ, ангиографи, компьютерт томографийн аппарат зэрэг эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдаад байна.

4.2. Бодлого боловсруулалт

2007 оны 9 сарын 18-нд Эрүүл мэндийн сайдын 242 тоот тушаалаар орон нутагт хорт хавдар өвчний хими эмчилгээг нэвтрүүлэх тухай шийдвэр гарч, хорт хавдрын хими эмчилгээг аймаг, дүүрэгт хийхээр болсон нь орон нутагт хавдрыг эмчлэх

чадавхийг бэхжүүлэх, үйлчлүүлэгчдээс гарах зардал чирэгдлийг багасгах боломжийг бүрдүүлсэн билээ.

2007-2016 оны ХСҮТ-ийн стратеги, төлөвлөгөөний матрицыг Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж жил бүрийн төлөвлөлтөнд тусган ажиллаж байна.

2011 онд ХСҮТ-ийн хамт олон “Хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны стратеги, төлөвлөгөө /2011-2021/”, “Туяа эмчилгээг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө /2011-2021/” –г боловсруулж батлуулаад хэрэгжүүлэх ажилдаа ороод байна.

ХСҮТ нь 2008 оноос хойш хорт хавдрын оношлогоо, эмчилгээний 46 стандарт боловсруулж батлуулан практикт хэрэглэж байна. 2008 оны 3-р сарын 25-нд ЭМ-ийн сайдын 75 тоот тушаалаар “Зарим хорт хавдар өвчний хими эмчилгээний удирдамж” батлагдсан бөгөөд үүний дагуу аймаг, дүүрэгт ажиллаж байгаа хавдар судлаач эмч нарыг хими эмчилгээний чиглэлээр 2 сарын богино хугацааны сургалтанд хамруулж мэргэшүүлсэн нь орон нутагт хорт хавдрын хими эмчилгээг нэвтрүүлж хавдрын тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчид ойртуулах боломж бүрдүүлсэн юм.

“Хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2010 оны 8-р сарын 30-ны өдрийн ЭМ-ийн сайдын 292 тоот тушаалд аймаг, дүүргийн түвшинд хавдрын тусламж, үйлчилгээг бэхжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, хэвтэн эмчлүүлэх ор бүхий бие даасан хавдрын тасаг байгуулах, аймаг, дүүргийн эмнэлэгт хорт хавдрын хими эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чадавхийг бэхжүүлэхээр заасан юм.

4.2. Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 246-р тогтоолоор батлагдсан “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр” 2006 оноос эхлэн, 2013 он хүртэлх хугацаанд хэрэгжиж байгаа билээ. Энэхүү үндэсний хөтөлбөрт зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчин (ХБӨ)-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, зонхилон тохиолдох ХБӨ-ийг эрт илрүүлэх, хянах нийтлэг асуудлыг тусгасан юм. “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр” ЭМ-ийн сайдын 2008 оны 9-р сарын 18-ны 210 тоот тушаалаар батлагдан, хэрэгжиж байгаа бөгөөд энэхүү дэд хөтөлбөрт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх, хянахад чиглэсэн илүү өвөрмөц стратеги, үйл ажиллагааг тусгасан болно.

“Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд доорхи ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Тухайлбал:

- ЭМ-ийн сайдын 2010 оны 5-р сарын 13-ны 176 тоот тушаалаар ЭМЯ-ны гол газар, хэлтэс, ХСҮТ, Эмгэг судлалын төв, Нийслэлийн ЭМГ, ЭМШУИС, ЦЭГ, “Хавдаргүй Монгол” үндэсний сан, ДЭМБ, МСС (Мянганы сорилын сан) зэрэг байгууллагын удирдах төлөөлөл оролцсон “Хорт хавдраас сэргийлэх хянах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг Удирдах хороог байгуулан, дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааг удирдаж, уялдуулан зохицуулах, хэрэгжилтийн явцыг хэлэлцэж, шийдвэр гаргах чиглэлээр ажиллаж байна.
- 2009 онд ХСҮТ нь “Хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдлын өөрийн үнэлгээг хийж, ДЭМБ-д тайлагнасан. Мөн онд Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-ийн үнэлгээний багийнхантай хамтарч хавдрын тусламж үйлчилгээний өнөөгийн байдалд хийсэн үнэлгээ нь ОУАЭА-аас “Хорт хавдрын Загвар хөтөлбөр” хэрэгжүүлэх 8 дахь орноор Монгол Улсыг сонгох шийдвэр гаргах үндэслэл болсон юм.

Ийнхүү Монгол улс ОУАЭА-ийн ПАКТ /Programme of Action for Cancer Therapy/–ийн загвар хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 8 дахь орон болж сонгогдсон нь хорт хавдрын тусламж үйлчилгээнд өндөр хүчин чадал бүхий оношлогоо, эмчилгээний аппарат багаж, тоног төхөөрөмжийг нийлүүлэх, туяа эмчилгээний их эмч, эмнэлгийн физикч, техникийн ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, хорт хавдрын тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад нөлөөлөх ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Энэ чиглэлээр 2010 оны 11-р сард “Хорт хавдрын тусламж, үйлчилгээг эмнэлгийн анхан шатны тусламжтай уялдуулах нь” сэдвээр Олон улсын хурлыг зохион байгуулж, түүнд Эрүүл мэндийн дэд сайд Ж.Цолмон болон ОУАЭА-ийн ПАКТ-ийн хөтөлбөрийн удирдагч Массуд Самэй, ДЭМБ-ын Женев дэх төвийн мэргэжилтнүүд, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Виват, ПАКТ-ийн жишиг хөтөлбөр хэрэгжүүлж буй 8 орны төлөөлөгчид оролцож, хорт хавдартай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа туршлагаасаа солилцжээ. Уулзалтын үеэр ХБӨ-ний анхан шатны тусламж үйлчилгээг хорт хавдрын тусламж үйлчилгээтэй уялдуулах талаар өрх, сумын эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэгт ХСҮТ-ээс хийсэн үнэлгээний дүнг танилцуулж хэлэлцүүлсэн байна.

Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, орон нутагт эрчимжүүлэх нь чухлаар шаардагдсан тул 2010 оны 2-р сарын 2-ний өдрийн ХСҮТ-ийн захирлын 19 тоот тушаалаар аймаг, дүүргийн Эрүүл мэндийн байгууллагуудын дунд болзолт уралдааныг зарлаж эхний жилийн үнэлгээний байдлаар Дорнод, Өмнөговь, Төв аймаг, Баянзүрх, Налайх дүүргийн ЭМН тус тус шилдгээр шалгарсан байна.

4.3. Хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлт ба эрт илрүүлэлтийн талаар явуулж буй үйл ажиллагаанууд

Хорт хавдраас сэргийлэх, ялангуяа эрсдэлт хүчин зүйлсээс зайлсхийх, эрүүл аж төрөх заншлыг хэвшүүлэх зорилгоор ХСҮТ-өөс доорх чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- ❖ Хавдартай тэмцэх дэлхийн өдөр, жил бүрийн 11-р сарын эхээр “Хорт хавдраас сэргийлье” 14 хоногийн аянаар захиалгат нэвтрүүлэг, сарын

эхний 14 хоногт олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хорт хавдраас сэргийлэх, эрсдэлт зан үйлээс зайлсхийх, эрүүл аж төрөх талаар мэдээлэл өгөх, хэвлэлийн бага хурал хийлгэх, төвийн сонинуудад материал нийтлүүлэх, телевиз, радио зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хорт хавдраас сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсээс зайлсхийх, эрт илрүүлэх чиглэлээр олон нийтэд тодорхой мэдээллүүдийг хүргэж байна.

- ❖ “Нээлттэй хаалга”-ны өдрийг тус төвийн тасаг, нэгж, албадууд зохион байгуулж, өөрсдийн үйл ажиллагааг сурталчлахын зэрэгцээгээр сувилахуйн тусламж үзүүлэх, цусны даралт, биеийн жин үзэх, эмч нар үйлчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнд зөвлөгөө өгөх, сурталчилгааны материалууд тараах, асуулт хариулт явуулах, лекц унших, видео кино үзүүлэх зэрэг ажлуудыг хийдэг.
- ❖ Орон даяар 30-60 насны эмэгтэйчүүдийн дунд хийгдэх умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд ХСҮТ-ийн эмч, мэргэжилтнүүдээс бүрдсэн техникийн ажлын хэсэг умайн хүзүү, хөхний өмөнгийн эмнэлзүйн удирдамж, стандартыг боловсруулж ЭМ-ийн сайдын 2011 оны 5-р сарын 10-ны 168 тоот тушаалаар батлуулж хэрэгжүүлэх ажилдаа ороод байна. Цаашид энэхүү удирдамж, стандартын чиглэлээр аймаг, дүүргийн сум, өрхийн эмч, эх барих эмэгтэйчүүд, хавдар судлаач, эс судлаач эмч, лаборант нарыг сургалтанд хамрах тодорхой төлөвлөгөө, график гарган ажиллаж байна. Илрүүлэг үзлэгт эсийн шинжилгээгээр онош тогтоох аргыг хэрэглэх болно. Монголын мянганы сорилын сангийн санхүүжилтээр аймаг, дүүргийг кольпоскопи, умайн хүзүүг цахилгаан гогцоогоор өөлөх, болон конус хэлбэрээр өөлөх аргаар эмчлэхэд шаардагдах аппарат багаж, тоног, төхөөрөмж, эм, урвалжаар хангах болно.
- ✚ ХСҮТ, “ХААН БАНК” сан, МҮОНРТ хамтран “Хавдрын эсрэг үндэсний аян-2011” –ыг ХСҮТ байгуулагдсаны 50 жил, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үүссэний 90 жилийн ойг угтсан үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулж байна. Уг аяны хүрээнд ХСҮТ-ийн мэргэжлийн эмч нарын баг аймаг бүрт ажиллаж хорт хавдартай хяналтын өвчтөнүүд, эрсдэлтэй бүлгийн хүн амын дунд эрт илрүүлэх үзлэг зохион байгуулж эмч, мэргэжилтнүүд болон сайн дурын ажилтнуудын сургалт зохион байгуулж, хавдраас сэргийлэх талаар хүн амын дунд мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулав.



Хавдрын эсрэг үндэсний аян – 2011-ын нээлтийн ажиллагаа 2011-02-04 он.

2011 оны 2-р сарын 10 өдөр, Улаанбаатар хот- Дэлхийн хавдартай тэмцэх холбооноос 2011 оны уриа болгон зарласан “Бид хамтдаа хүчтэй” олон улсын аяны агуулга, зорилтын хүрээнд Хавдар судлалын үндэсний төв, ХААН Банк Сан, МҮОНРТ-ээс хамтран “Хавдрын эсрэг үндэсний аян-2011” хэрэгжүүлэхээр болж талууд хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан.

Уг аян нь 2011 оны 4 дүгээр сарын 18-ний өдөр Сэлэнгэ аймгаас гараагаа эхэлж Дархан-Уул, Архангай, Говь-Сүмбэр, Дундговь, Баян-Өлгий, Увс, Ховд, Төв зэрэг 9 аймагт ажилласан бол 2011 оны 6-р сарын 11-ний өдрөөс эхлэн ХСҮТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй тус бүр 10 эмч, мэргэжилтнээс бүрдсэн 3 баг Баруун бүс /Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь/, Зүүн бүс /Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь/, Төвийн бүс /Хөвсгөл, Булган, Орхон, Өвөрхангай/ аймгуудад ажиллахаар нэгэн зэрэг замд гарч 21 аймагт “Хавдрын эсрэг үндэсний аян-2011” амжилттай явагдаж дууслаа.



21 аймагт ажиллах 3 бүсийн багийн эмч нарыг үдэх нээлтийн ажиллагаа,



Архангай аймгийн ард иргэдэд “Хавдрын эсрэг үндэсний аян-2011”-ийхэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 2011 он.



Хавдрын эсрэг аяны хүрээнд 21 аймагт хийсэн ажил

Аяны хүрээнд хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх хүн амын мэдлэгийг дээшлүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил хийх, эрсдэлт бүлгийн хүн амыг хавдрын нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах, сум, өрхийн эмч болон холбогдох бусад мэргэжлийн эмч нарыг хорт хавдрын оношлогоо, эмчилгээний чиглэлээр сургалтанд хамруулах, ХААН банкны орон нутгийн сайн дурын ажилтнуудыг хавдраас сэргийлэх, эрсдэлт зан үйлээс зайлсхийх чиглэлээр сургалтанд хамруулах, хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт нь хянаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулсан.

Мэдээлэл сурталчилгаа

Олон нийтэд зөв мэдээ мэдээлэл хүргэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг сурталчлан таниулах нь аяны хамгийн нэг чухал зорилт юм.

- Хавдраас сэргийлэх талаарх мэдээллийг санамж 37100, зурагт хуудас 660 ширхэг сурталчилгааны материалыг тарааж төвийн болон орон нутгийн 80 орчим телевиз, радиогийн мэдээ, тусгай нэвтрүүлгүүд, 200 орчим сонин сэтгүүл, вэбсайтаар /сэтгүүлчдийн дунд зарласан уралдааны бүтээлүүд багтсан болно/ дамжуулан хүн амд хүргэсэн байна.
- Аяны бас нэгэн бүрэлдэхүүн хэсэг болох сонин, вэбсайтын болон чөлөөт сэтгүүлчдийн дунд 5-р сарын 1-ээс 6-р сарын 25-ны хооронд зарласан шилдэг бүтээлийн уралдаанд 130 гаруй бүтээл нийтлэл ирсэн нь тэр хэмжээгээр олон нийтийг хорт хавдраас урьдчилан сэргийлэх мэдлэгийг сайжруулсан нь дамжиггүй юм.
- 2011 оны 2-р сараас хойш ХСҮТ болон Хаан банк хамтран 3-р цахилгаан станц, Хил хамгаалах ерөнхий газар, Авилгалтай тэмцэх газрын 280 гаруй албан хаагчдад хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай цогц мэдээ мэдээллийг өгсөн.
- Мөн 2011 оны 6-р сарын 10-ны өдөр Сүхбаатарын талбайд аяны нээлтийн үйл ажиллагаа болсоны зэрэгцээ олон нийт, иргэдэд хандсан мэдээллийн өдөрлөгийг давхар зохион байгууллаа.

Эрсдэлтэй бүлгийн хүн амд хийгдсэн үзлэг

- ХСҮТ-ийн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийн баг болон ХААН Банкны салбарын ажилтнууд шуурхай зохион байгуулалт хийсний дүнд анхан шатны эмнэлгийн тодорхойлолт бүхий эрсдэлт бүлгийн ард иргэдийг хамруулсан 17838 үзлэг оношлогоо хийснээс хортой хавдар гэж сэжиглэгдэж буй 309, хоргүй хавдар 1744, хавдрын урьдал өвчин 1386-ыг илрүүлсэн байна.
- Орон нутагт эсийн шинжилгээ 1296-г хийснээс 634-ийн оношийг баталгаажуулж, зарим аймгийн эс судлаач эмч нарыг ажлын байранд нь дагалдуулан сургалаа.
- Орон нутагт ажилласан ХСҮТ-ийн эмч мэргэжилтнүүд 100 гаруй мэс заслыг орон нутагт хийж зарим эмч нарыг орон нутагт нь дагалдуулан сургасан байна. Онош нь тодорсон олон хүн ХСҮТ дээр ирж эмчилгээ хийлгэх, мэс засалд орох зэргээр эмнэлгийн тусламж авч байна.



“Хавдрын эсрэг үндэсний аян-2011”-ийн Зүүн бүсийн ахлагч Мэс заслын тасгийн эрхлэгч Д.Ягаан сайн дурынханд хичээл зааж байх үеэр. 2011 он.



С.Хүрэлсүх ахлагчтай Хавдрын эсрэг үндэсний аян-2011-ын Баруун бүсийн эмч нар. 2011 он.



Г.Пүрэвсүрэн ахлагчтай Төвийн бүсийн хамт олон, 2011 он.





Я.Эрдэнэ-Очир ахлагчтай баруун 3 аймгийн баг

Эмч эмнэлгийн ажилтан болон сайн дурын ажилтанд зориулсан сургалт

- “Зонхилон тохиолдох хорт хавдрын оношлогоо эмчилгээ” сэдэвт 2 кредитын сургалтанд 21 аймгийн 1296 орчим эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.
- Хаан банкны сайн дурын ажилтан 510 гаруй сайн дурын идэвхтэнүүдийг бэлтгэсэн бөгөөд тэд цаашид орон нутагтаа хорт хавдраас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг ард иргэдэд зохион байгуулалттай хүргэх юм.

Хавдрын эсрэг аян 21 аймаг зохион байгуулагдсанаар дуусахгүй бөгөөд 2011 оны 9-10-р сард Улаанбаатар хотод үргэлжлэн хийгдэх ба нийслэл хотын эрсдэлт бүлгийн иргэдийг үзлэг оношлогоонд хамруулж, дүүрэг бүрт сайн дурын идэвхтний баг бэлтгэнэ.

Хорт хавдрын өвчлөл, нас баралт дэлхий дахин болон Монгол Улсад өсөн нэмэгдэж байгаа энэ цаг үед хүн ардад хэрэгцээтэй, үр өгөөжөө өгсөн төсөл хэрэгжүүлж буйд орон нутгийн ард иргэд талархан хүлээн авч аяныг зохион байгуулагчид баяртай байгаа төдийгүй 2012 онд үргэлжлүүлэн зохион байгуулахаар шийдвэрлэсэн юм.

Эрүүл мэндийн байгууллага дангаараа хавдартай тэмцэх биш энэ үйлсэд хувь хүн, гэр бүлийн гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллаж байгаа нь ач холбогдлоо өгөх болно.



Хавдрын эсрэг үндэсний аян-2011-ын уулзалт семинар,



4.4. Оношилгоо, эмчилгээнд нэвтрүүлсэн технологийн шинэчлэл

ХСҮТ-д сүүлийн жилүүдэд дараахь чиглэлийн технологийн дэвшил оношлогоо-эмчилгээнд нэвтэрч, тодорхой үр дүнгээ өгч байна. Тухайлбал:

- 2007 оноос туяа эмчилгээг 3 хэмжээст технологид шилжүүлэх үйл ажиллагааг шат дараатай хийж гүйцэтгэж байна. Үүнд: 2007 онд компьютерт томографт симулятор аппарат, 2008 онд 3D физик төлөвлөлтийн систем нэвтэрсэн. 2011 оноос 5 бункер бүхий туяа эмчилгээний хэсэг байгуулахаар төлөвлөж байна. 2010 оны 3-р сард Герман Улсын Bebig компаний өндөр идэвхижилттэй “Co-60” үүсгүүр бүхий дотуур туяа эмчилгээний аппаратыг ОУАЭА-ийн төслийн шугамаар шинээр ашиглалтанд оруулсан.

- 2007 оны 11-р сард Монгол Улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар компьютерт томографт симулятор аппаратыг суурилуулсанаар, Монгол Улсад эмчилгээ 3 хэмжээст технологид шилжих эхлэл тавигдав.
- 2010 онд улаан хоолойн доод болон дунд 1/3-ийн хорт хавдар болон ходоодны орох хэсгийн хавдар улаан хоолой руу нэвчин орсон үед цээжний зүүн хүрцээр өрцийг нээж ходоодыг суллан, улаан хоолойг тайрч ходоодтой нь залгах мэс заслын аргыг нэвтрүүлээд байна.
- 2010 оны 6-р сард анх удаа элэгний үүдэн венийн судас бөглөх (PVE) эмчилгээг амжилттай хийв. Уг ажилбарыг хийснээр үлдэх элэгний хэмжээг томруулж 2 үе шаттай мэс засал хийх шаардлагагүй болсон байна.
- Нойр булчирхайн дисталь хэсгийн өмөнгийн үед нойр булчирхайн их бие, сүүл хэсгийг дэлүүний хамт тайрч, өргөтгөсөн лимфийн булчирхай түүх хагалгааг /Radical Antegrade Modified Pancreato Splenectomy/ 2010 оны 9-р сараас хойш хийж эхлээд байна.
- 2010 оноос умайг үтрээгээр хэвлийн хөндийн дурангийн хүрцээр авах мэс заслын аргыг хэрэглэж эхлэв. Энэ хагалгааг нэвтрүүлснээр хагалгааны дараахи хүндрэл багасан эмчлүүлэгчдэд сорвигүй, нөхөн үржихүйн эрхтэн хадгалагдах, мэс заслын дараах өвдөлт бага байх, ор хоног багассанаар эм тариа, ороох боох материалын зардал хэмнэгдэх зэрэг давуу талууд гарлаа.
- Гармоник скальпелаар паротидэктоми мэс заслыг амжилттай хийсэн бөгөөд уламжлалт мэс заслын аргатай харьцуулахад хагалгааны хугацаа богиносч, хагалгааны явцад гарах цус алдалт, нүүрний мэдрэлийн гэмтэл, мэс заслын дараахи шарх орчмын өвдөлт эрс багасч байна. Гармоник скальпелаар бамбайн мэс засалд хэрэглэснээр бамбайн артери венүүдийг утсаар боох, бамбайн эдийг оёх шаардлагагүй болсон нь орчны эд гэмтэх, халах, утаа гарах зэрэг байдал гаргахгүй болсон давуу талтай юм.

4.5. Хавдрын оношлогоо, эмчилгээнд нэвтрүүлсэн тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл

- 2007 оноос хойш оношлогоонд ходоод, уушиг, гэдэс, хамар, нармай, залгиур төвөнхийн уян дуран 3 ширхэг, хэт авиан оношлогооны суурин аппарат 4 ширхэг, дижитал рентген аппарат, маммографи, гистероскопи, унтуулгын аппарат, эрчимт эмчилгээний багаж тоног төхөөрөмж, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, 3 толгойт микроскопи, өндөр давтамжит радио долгионоор хавдрыг шарах аппарат, 3 хэмжээст төлөвлөлтийн систем, хөлдөөгч микротом, иммунологи-биохими, гематологийн анализаторууд ариутгалын аппарат тоног төхөөрөмж ашиглах болсоноор оношлогооны хүчин чадал бэхжив.
- 2008 оноос химийн эм найруулах шүүгээ/Ламинар бокс/ -тэй болж химийн эм тариа найруулахад хэрэглэдэг болсон.
- Герман улсын Be big компаны өндөр идэвхижилттэй Co-60 үүсгүүр бүхий дотуур туяа эмчилгээний аппарат-2010 он
- 2010 онд теле конференцийн тоног төхөөрөмжийг эмч нарын зөвлөгөөний өрөө, эрдмийн өргөө, мэс заслын өрөөнд байрлуулж хавдрын өндөр нарийн

- мэргэжлийн эмч нар аймаг, дүүргийн эмч нарт зайнаас зөвлөгөөт тусламж үзүүлэх ажил нэвтэрлээ.
- 2010 оноос Leica CM 1510 S хөлдөөгч микротом суурилуулан элэг болон хөхний экспресс шинжилгээ хийгдэж байна. Улсын хэмжээнд шинээр иммуногистохимийн 8 төрлийн урвалжийг шинжилгээнд нэвтрүүллээ.

4.6. Шинэчлэл, өөрчлөлтийн шинжтэй бусад арга хэмжээнүүд

ХСҮТ-ийн өргөтгөлийн барилга

2007 оноос ХСҮТ-ийн өргөтгөлийн барилга барих шаардлагатай байгаа тухай үндэслэл саналыг боловсруулж холбогдох байгууллагуудад асуудлыг удаа дараа тавьснаар Монгол улсын Засгийн газар, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар өргөтгөлийн барилгыг 2010-2012 онд барихаар санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн. Төвийн өргөтгөл нь эмнэлгийн үйлчилгээний цогцолбор барилга юм. Барилга нь эмнэлгийн үйлчилгээнд ашиглах нийт 5200м² орчим талбай бүхий газар давхрын хамт дөрвөн давхараас бүрдэнэ.



Тус барилга нь эмнэлгийн үйл ажиллагаа явуулах зориулалтын өрөө, тасалгаатай, дэд бүтэц нь бүрэн шийдэгдсэн, гадна талбай нь бүрэн тохижигдох цогцолбор байх юм.

Газар давхарт нөхөн сэргээх эмчилгээний хэсэг, номын сан, усан бассейн, бялдаржуулах өрөө байрлана. 1-р давхарт Туяа эмчилгээний хэвтэн эмчлүүлэх хэсэг, оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжийн хэсэг, 2-р давхарт Хими эмчилгээний тасаг, хурлын заал, уулзалтын өрөө, 3-р давхарт Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын төв, хагалгаа, эрчимт эмчилгээний хэсэг байрлахаар төлөвлөгдөөд байна.

Өргөтгөлийн барилга ашиглалтад орсноор тус төвийн эмчилгээ, үйлчилгээний чадавхи 30 гаруй хувиар нэмэгдэх боломжтой юм.

Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ

Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний тухайд зарим ахиц, дэвшил гарч байна. Одоо ХСҮТ-ийн хэмжээнд жилдээ 700 гаруй өвчтөнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлж байна. Улаанбаатар хотын зарим дүүрэгт болон ихэнхи аймгийн нэгдсэн эмнэлгийн стационарт 2-5 орыг хорт хавдартай өвчтөнд хөнгөвчлөх тусламж үзүүлэхэд ашиглаж байна. Төгсөлтийн дараах хөнгөвчлөх эмчилгээний курсээр

эмч, сувилагч нарыг бэлтгэж байна. Мөн ЭМШУИС-ийн оюутны сургалтын хөтөлбөрт хөнгөвчлөх тусламж үйлчилгээний асуудал нэлээд тодорхой тусгагдаж, оюутнууд ХСҮТ дээр энэ чиглэлийн дадлага хийдэг болоод байна.

Хавдрын бүртгэл, мэдээлэл

ХСҮТ-ийн зүгээс хавдрын бүртгэл мэдээллийг сайжруулан, боловсронгуй болгоход анхаарч байна. Тус төв нь Олон улсын хорт хавдрын бүртгэл, судалгааны төв /IARC/ -тэй холбогдож, Монгол Улсын хүн амын хорт хавдрын өвчлөл, нас баралтын талаарх мэдээллийг GLOBOCAN –д тавьж мэдээлэл солилцож байна. Монгол Улсын хорт хавдрын өвчлөлийн мэдээллийг олон улсад мэдээлж, бусад улс орны энэ чиглэлийн мэдээллийг ч хүлээн авах нөхцөл нэгэнтээ бүрдсэн болно.

2010 оны 6-р сараас ХСҮТ ба МСС-тай хамтран “Хорт хавдрын бүртгэл мэдээлэл, эргэн дуудах тогтолцоо” төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь 3 үндсэн үе шат, 7 бүлэг үйл ажиллагааны хүрээнд хавдрын бүртгэлийн чадавхийг бэхжүүлэх, олон улсын стандартад нийцсэн програмыг боловсруулан үндэсний хэмжээнд ашиглах, хавдрын эргэн дуудах тогтолцоог шинээр бүрдүүлэх зорилготой юм. Уг төслийн хүрээнд хавдрын бүртгэл, эргэн дуудах тогтолцооны өнөөгийн байдал, хэрэгцээг үнэлсэн юм. Цаашид аймаг, дүүрэгт хавдрын бүртгэлд зориулсан компьютер техник хэрэгслээр хангаж, эмч мэргэжилтнийг сургах, хөх, умайн хүзүүний хорт хавдрын скринингийн мэдээллийг шинээр програмд оруулан мэдээний сан үүсгэх, дүн шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Мөн хавдрын бүртгэлийн шинэчилсэн маягтууд AM5, AM7, ЭМЯ-ны альбомд тавигдсан ба 2007 оны 5-р сараас ХСҮТ-д цахим эмнэлэг программыг нэвтрүүлж эхэлсэн юм. 2011 оны байдлаар, амбулаторийн 14 кабинет сүлжээнд холбогдон, тогтмол ажиллаж, үйлчлүүлэгчдийг хүлээлгэлгүй, шуурхай үйлчлэх зорилготой ажиллаж байна. Үйлчлүүлэгчдийг түргэн шуурхай мэдээллээр хангах зорилгоор ХСҮТ-д хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний хагалгааны тухай мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлж шинэлэг програм хангамжийг санаачлан ажилласан. Хагалгаа хийлгэж буй өвчтөний ар гэрийхэнтэй уулзах уулзалтын өрөөнд 19 инчийн ЛСД дэлгэц 4 ширхэг, хагалгааны өрөөнд иж бүрэн компьютерийг програм хангамжийн хамт тус тус суурилуулснаар, үйлчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх боломж бүрдлээ. Энэхүү програмд хагалгаа хийлгэх өвчтөний нэр, хагалгааны нэр, явц, гардан хийж буй эмч нарын нэрс, эхлэх, дуусах цагийн тухай мэдээлэл багтдаг болно.

4.6. Хорт хавдрын судалгаа шинжилгээний түүхээс

Манай орны хавдрын талаарх судалгаа шинжилгээний ажлын хөгжил хавдар судлалын бие даасан албаны үүсч хөгжсөн түүхэн үе шаттай холбоотой. Монголын эрүүлийг хамгаалахын хөгжлийн үе шат, хорт хавдрыг оношлож, эмчилж байсан практик үйл ажиллагаа, зарим эмч, эрдэмтдийн бичиж хэвлүүлсэн материалд тулгуурлан хавдар судлалын эрдэм судлалын ажлын түүхийг дөрвөн үе болгон ангилан авч үзэж болох юм.

1.1960 он хүртэл

Хавдар судлалын бие даасан тусламж бий болох хүртэл буюу 1921-1960 оныг дуустал үеийг хамрана. Эрүүлийг хамгаалахын хөгжлийн эхэн үе болох 1921-1940 онуудад үндэсний боловсон хүчин байхгүй, хорт хавдартай тэмцэх нэгдсэн бодлогогүй гадаадаас уригдан ирсэн цөөн тооны эмч болон өөрийн орны лам, хуврагууд хавдартай хүмүүст шинж тэмдгийн болон сэтгэл санааны засал хийх төдийхнөөр тусламж үзүүлж байжээ. Мөн энэ үед хүн амын дунд бэлгийн замын болон бусад халдварт өвчний тархалт элбэг байсан нь хорт хавдартай тэмцэх асуудал орхигдох үндэслэл болсон байна.

Хорт хавдрын тархварзүйн судалгаа эхний үед бусад орнуудын нэг адил эмнэлгийн дүн бүртгэл, задлан шинжилгээний материалд тулгуурлаж байв. Манай улсад “Улаан хоолой, ходоодны амсрын өмөн” элбэг байгаа тухай материалыг анх удаа академич Т.Шагдарсүрэн 1960 онд нийтлүүлжээ.

2. 1961-1980он хавдар судлалын материалаг бааз бүрэлдэн бий болж мэргэжлийн боловсон хүчин бий болсон үе

Хавдрын мэс заслын төгс эмчилгээний арга нэвтрэхэд ЗХУ-ын мэргэжилтнүүд онцгой үүргийг гүйцэтгэсэн юм.

Эмэгтэйчүүдэд тохиолдох өмөнгийн байдалд судалгаа хийж улмаар мэс заслын эмчилгээг клиникт Т.Е.Цацниди, В.С.Соловьев нар нэвтрүүлсэн байна. Эдгээр хүмүүс өндгөвчийн хагалгаа хийх боломжгүй өмөнгийн үед даавар эмчилгээг урьдчилан хийж хавдрын хэмжээ багасаж, хөдөлгөөнтэй болсны дараа уг хавдрыг мэс заслын аргаар авч байсан нь нэг талаар хавдар өвчний үед эмчилгээний бүрдэл аргыг нөгөө талаар хорт хавдрын эмчилгээний хамгийн ирээдүйтэй залуу салбар болох эмийн эмчилгээний чухал хэсэг даавар эмчилгээг манайд анх удаа туршин хэрэглэж зохих үр дүнд хүрчээ.

В.В.Соловьев (1960) нар “Тус улсад өмөн өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулах ба хөдөлмөрчдийн дунд урьдчилан сэргийлэх үзлэг тогтмол хийж байх явдал чухал байна. Эрүүлийг хамгаалах байгууллагаас өмөн өвчинтэй тэмцэх тэмцлийг тогтмол төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах цаг болжээ” гэж онцлон тэмдэглэсэн байна.

3. 1981-1999 онд хавдар судлалын чиглэлээр судалгаа хийх сектор байгуулагдаж хавдар судлалын судалгааны ажлын чиглэл бий болсон нь

Хавдар судлалын төвийн шинэ байр ашиглалтанд орж, 1983 онд хавдар судлалын чиглэлээр судалгаа хийх сектор Анагаах ухааны хүрээлэн /АУХ/-д байгуулагдсан нь хавдрын судалгааны суурь тавигдаж, улмаар энэ чиглэлийн эрдэм шинжилгээний ажил хийх нөхцөл бүрдсэн юм. Энэ сектор анх эрдэм шинжилгээний 3 ажилтан, туслах 2 ажилтантай үйл ажиллагаагаа эхэлж байжээ. Энэ үед хорт хавдрыг эрт оношлох, мэс засал, туяа, химийн эмчилгээний аргыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийгдэж эхэлсэн байна.

2000-2011 оны судалгааны ажлын үр дүн

2000 оноос хойших хугацаанд судалгааны ажлын цар хүрээ нэмэгдэж судалгааны үндсэн чиглэл хорт хавдрын анхдагч ба хоёрдогч урьдчилан сэргийлэлт, үүсгэх хүчин зүйлсийн судалгаа чиглэл рүү ойртож хавдар үүсэхэд, вирус удам зүйн нөлөөллийг судлах чиглэл рүү анхаарч ажиллаж байна.

2000-2003 онд хорт хавдрын урьдчилан сэргийлэлт нэртэй төсөл хэрэгжүүлж дууссан. Энэ төсөл хавдрын анхдагч сэргийлэлт, хавдрын хоёрдогч сэргийлэлт ба эмчилгээ, туршин-шинжлэлийн хавдар судлал, хавдрын эерэг болон хавсарга эмчилгээний зориулалттай шинэ эм гэсэн 3 дэд төслийн хүрээнд хийгдэж, эрдэм шинжилгээний өгүүлэл-28, ном-3 туурвигдсан юм. Мөн судлаач доктор М.Амбага, Р.Шинэхүү, доктор Д.Самбуупүрэв нар туршилтын амьтанд элэгний өмөнгийн загвар үүсгэх, Д.Авирмэд, М.Шоовдор нар цусны болон өндгөвчний хавдрын дам суулгавар үүсгэх зэрэг туршилт шинжилгээний ажлууд нь зарим эрхтний хорт хавдар үүсэх механизмыг өөрийн орны нөхцөлд судлах боломжийг бий болгосон онол практикийн үндэслэл юм. Мөн тус төслийн туршилт шинжилгээний лабораторийг түшиглэж эмнэлзүйн туршилт хийж практикт нэвтрүүлсэн доктор М.Амбага нарын бүтээсэн хорт хавдрын үеийн дархлааны дутагдлыг зүгшрүүлэх “Салимон” шинэ эмийн бэлдмэл нь эмчилгээний практикт нэвтэрч үр дүнгээ өгсөөр байна.

2004-2006 оны хооронд хавдар судлалын секторын хүрээнд “Монголд зонхилон тохиолдох хорт хавдрын вирус удамзүйн шалтгааныг судлан эрт илрүүлж, оношлох, эмчлэх аргууд” сэдэвт төсөл хэрэгжүүлсэн байна.

Энэ төслийн хүрээнд Монголд зонхилон тохиолддог зарим байрлалын (элэг, ходоод, умайн хүзүү) хорт хавдар үүсэхэд вирус удам зүйн нөлөөлөл байгаа эсэхийг судалж эрт илрүүлж оношлох аргыг практикт нэвтрүүлэхэд чиглэгдсэн судалгааны ажил хийгджээ.

2007-2009 оны хооронд “Хорт хавдрын эрт илрүүлэлт эдийн засгийн үр ашгийн судалгаа, сэргийлэх арга зам сэдэвт төслийн ажил гүйцэтгэсэн.

Уг төслийн хүрээнд дараах судалгаа хийгдсэн. Үүнд:

1. Зарим эрхтний хорт хавдрын онош хожимдлын шалтгааныг судлах,
2. Хорт хавдар түүний урьдал өвчнийг эрт илрүүлэх 3 шаттай үзлэг зохион байгуулж үр дүнг тооцох,
3. Хорт хавдрын эрт илрүүлэлтийн нийгэм эдийн засгийн үр ашгийн тооцоог гаргах.

Төслийн хугацаанд эрдэм шинжилгээний өгүүлэл 14, үүнээс гадаадад хэвлүүлсэн бүтээл 3, оновчтой саналын гэрчилгээ 2, аргачилсан зөвлөмж 2, ном 1 тус тус туурвигджээ.

2009-2011 онд хорт хавдрын эрт илрүүлэлтийг сайжруулж, эрхтэн хадгалах мэс заслын аргыг практикт нэвтрүүлэх чиглэлээр шинэ төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэн, судлаачид



2006 он О.Уранчимэг. Ходоодны өмөнгөөр өвчлөгсдийн хими эмчилгээний зардалд хийсэн эмийн эдийн засгийн шинжилгээ.



2007 он Я.Эрдэнэ-Очир. Ходоодны дээд хэсгийн өмөнгийн мэс засал эмчилгээ.



2009 он Р.Асай. Хөхний өмөнгийн рентген оношлогооны асуудалд.



2009 он Э.Амарсанаа. Хөхний өмөн үүсэхэд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйл.

 2010 он. А. Болд. БНХАУ. Улаан хоолойн төгс мэс заслын олон аргуудыг харьцуулсан эмнэлзүйн судалгаа.	 2009 он. Б. Баасанжав. Япон Улс. Цулцан хураа өвчний дараа жирэмслэлттэй холбоотой трофобластик неоплазид шилжих магадлал нь хетерозигот хэлбэрт хомозигот хэлбэрээс өндөр.
 2010 он. М.Минжмаа. ХБНГУ. Туяа эмчилгээний дараах хавдрын эсүүдийн амьдрах чадамж болон үржилд K-RAS генийн ач холбогдол.	2006 он. Ж.Амарсанаа. Япон Улс. Тогтвортой RNAi технологи хэрэглэн нойр булчирхайн хорт хавдрын Smad4 уургийг дарангуйлан хорт хавдрын генийн профилийг судалсан нь.

ХСҮТ-ийн эрдмийн зөвлөл 2007 онд шинээр зохион байгуулагдаж, бүрэлдэхүүнд нь академич 2, анагаахын шинжлэх ухааны доктор 3, анагаах ухааны доктор 10, нийт 15 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2007 оны 12 –р сард хавдрын судалгааны тэргүүлэх чиглэлүүдийг ХСҮТ-ийн эрдэмтэд хамтран боловсруулж, эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол хүн амын дунд зонхилон тохиолдох хавдрын эпидемиологи,
- Хавдартай тэмцэх, сэргийлэх талаар баримталж байгаа бодлого, хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөө,
- Зонхилон тохиолддог хорт хавдрын эрт илрүүлэлт, оношлогоо, эмчилгээний байдал, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж

Одоогийн байдлаар ХСҮТ-д дараах судалгаа шинжилгээний ажил явагдаж байна. Үүнд:

- Умайн хүзүү, хөхний өмөнгийн эмчилгээний дараахь амьдрах хугацааны судалгаа,
- Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэлтийн эдийн засгийн үр ашгийн судалгаа.

Азийн элэгний анхдагч өмөнгийн судалгааны төвтэй:

- Мэс заслаар тайрах боломжгүй үсэрхийлсэн болон даамжирсан элэгний хорт хавдарт неоадьювант хими эмчилгээний үр дүнг тооцох,
- Хэсэг газрын даамжирсан элэгний хорт хавдрын үед сонгомлоор дотуур туяа эмчилгээ (SIRT) ба сорафенибээр эмчлэх олон төвт харьцуулсан хяналттай фаз III эмнэлзүйн судалгааг тус тус хамтран хийж байна.

Мөн “МОНОС” эрдэм шинжилгээний төвтэй “Элэг, умайн хүзүүний хорт хавдрыг эмчлэх эллипин эмийн эмнэлзүйн туршилт судалгаа”-г хийж байна.

4.7. Төслүүд болон төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаа

ХСҮТ нь сүүлийн жилүүдэд дотоодын байгууллага, хамт олонтой хамтран, тодорхой төсөл хэрэгжүүлэх, үр дүнд хүрэх талаар багагүй ажил хийж байна. Энэ бол тус төвийн шинэлэг үйл ажиллагааны бас нэгэн тал юм. Одоогийн байдлаар дараахь чиглэл бүхий төслийг хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✚ “Хямралын эсрэг хамтдаа” аяны хүрээнд МҮОНРТ-ээс хүүхдийн эмчилгээний хэсэг байгуулах төсөл. МҮОНРТ-ээс санаачлан, бүх орон даяар хамарсан аяны хүрээнд цугласан хандивыг туяа эмчилгээний тасагт хүүхдийн тоглоомын өрөө, интернет булан, эцэг эхчүүдийн амрах өрөө, хүүхдийн хэвтэн эмчлүүлэх 6 ортой 2 өрөө, эрчимт эмчилгээний иж бүрэн тохижуулсан өрөөг тус тус байгуулснаар иж бүрэн хэсэг болсон.
- ✚ ММСС-ийн Эрүүл мэндийн төсөлтэй хамтарсан “Хавдрын бүртгэл мэдээлэл, эргэн дуудах тогтолцоог сайжруулах” төсөл. Хавдрын бүртгэл мэдээллийн өнөөгийн байдлын хэрэгцээг үнэлж, бүртгэлийг 21 аймаг, 9 дүүрэгт бэхжүүлэхийн тулд компьютер, програмаар хангаад, хавдрын эмч болон бүртгэлийн ажилтанг сургах үйл ажиллагаа зохион байгуулж байна. Мөн ХСҮТ-д төв серверийн өрөөг 2010 онд байгуулсан.
- ✚ Олон улсын байгууллагуудын гэргий нарын нийгэмлэгийн “Хүүхэд салхилах, тоглоомын талбай байгуулах” төсөл. 2010 оны 7-р сард Австри Улсын Вена хотод байдаг уг нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн хатагтай Л.Хажидсүрэн манай төвд зочилж, эмнэлгийн орчинтой танилцан, “Нарны гэрэл + ногоон ургамал + үеийн хүүхдүүд = аюулгүй байгалийн орчин” төслийн хөрөнгө оруулалтыг шийдэж, талбайг тохижуулах ажил хийгдсэн.

4.8. Төгсөлтийн дараах сургалт

ХСҮТ нь төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах чиглэлээр 2000-2010 онд ахиц, дэвшил гаргасан юм. Тухайлбал, 2000 оноос эхлэн хавдар судлаач эмчийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын орчинг бүрдүүлэх ажлыг

хийсэн. ЗГХА-ЭМГ-ын зөвшөөрөлтэйгээр дараах чиглэлээр төгсөлтийн дараах сургалтыг явуулж байна. Үүнд:

- 1) Хавдар судлаач эмчийн резидентурын сургалт,
- 2) Эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмчийн төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалт,
- 3) Хөнгөвчлөх эмчилгээний эмч, сувилагч бэлтгэх сургалт,
- 4) Хими эмчилгээний эмч, сувилагч бэлтгэх сургалт,
- 5) Хавдрын сувилагчийн мэргэжил олгох сургалт,
- 6) Мэс заслын сувилагчийн мэргэжил олгох сургалт,
- 7) Эрчимт эмчилгээний сувилагчийн мэргэжил олгох сургалт.



Хавдар судлаач эмчийн резидентурын анхны төгсөлт, 1985 он

2000-2011 оны хооронд нийт нийт 10 удаагийн төгсөлтөөр 81 хавдар судлаач эмч бэлтгэсний 85% нь мэргэжлээрээ ажиллаж байна. 2010 оны 9-р сарын 24-ны өдрийн 4 тоот Эмнэлгийн мэргэжилтний хөгжил, төгсөлтийн дараах сургалтын зөвлөлийн шийдвэрээр “Хавдар судлаач эмчийн мэргэжлээр үндсэн мэргэжил эзэмшүүлэх резиденсийн 1 жилийн сургалт”-ыг 4 хүртэл жилийн хугацаатайгаар эрхлэх эрхийг шинэчлэн олгосон.

Эмэгтэйчүүдийн хорт хавдартай тэмцэх нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмч”-ийн мэргэжил олгох 6 сарын сургалтыг 2005 оноос хойш зохион байгуулж байгаа бөгөөд нийт 21 эмч суралцан төгссөнөөс 9 эмч ХСҮТ-д, 4 эмч аймгийн нэгдсэн эмнэлэгт, 2 эмч ЭНЭШТ-д, 5 эмч хувийн хэвшилд эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байна.

ЭМ-ийн сайдын 2007 оны 9 –р сарын 18-ны “Орон нутагт хавдрын өвчний хими эмчилгээг нэвтрүүлэх” тухай 242-р тушаалын 2Б заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2008 оноос хавдрын эмч нарын хими эмчилгээний чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 2 сарын сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Одоогоор нийт 34 эмч хавдрын хими эмчилгээний мэргэжил дээшлүүлэх сургалтыг төгсөөд аймаг, дүүргийн хавдрын кабинетад ажиллаж байна.

Тус төвийн Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн алба нь 2002 оноос эхлэн хавдрын, мэс заслын, эрчимт эмчилгээний сувилагчийн мэргэжил олгох 3 сарын сургалтуудыг зохион байгуулсан ба тэдгээрт нийтдээ 196 сувилагч хамрагдсан. Үүнээс эрчимт эмчилгээний сувилагч 98, мэс заслын сувилагч 40, хавдрын сувилагч 58 төгссөн байна.

2010 онд ХСҮТ-өөс санаачлан хавдар судлаач эмчийн үндсэн мэргэжил олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, ЭМЯ-ны Хавдрын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, эмнэлгийн мэргэжилтний хөгжил, сургалтын зөвлөлөөр хянуулж, батлуулсан.

**Хавдар судлаач эмчийн резидентурын сургалтыг
төгсөгчдийн тоо**

<i>Хүснэгт</i>		
№	Хичээлийн жил	Төгсөгчдийн тоо
1	2000- 2001 оны хичээлийн жилд	11
2	2001- 2002 оны хичээлийн жилд	9
3	2002- 2003 оны хичээлийн жилд	10
4	2003- 2004 оны хичээлийн жилд	10
5	2004- 2005 оны хичээлийн жилд	12
6	2005- 2006 оны хичээлийн жилд	9
7	2006- 2007 оны хичээлийн жилд	4
8	2007- 2008 оны хичээлийн жилд	4
9	2008- 2009 оны хичээлийн жилд	5
10	2009- 2010 оны хичээлийн жилд	10
	Бүгд	81

Эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмчийн сургалтыг төгсөгчдийн тоо

<i>Хүснэгт</i>	
Хичээлийн жил	Төгсөгчдийн тоо
2004- 2005 оны хичээлийн жилд	9
2005- 2006 оны хичээлийн жилд	2
2006- 2007 оны хичээлийн жилд	1
2007-2008 оны хичээлийн жилд	1
2008-2009 оны хичээлийн жилд	2
2009-2010 оны хичээлийн жилд	6
Бүгд	21

**Хавдрын хими эмчилгээний мэргэжил дээшлүүлэх сургалтыг
төгсөгчдийн тоо**

Хүснэгт

Хичээлийн жил	Төгсөгчдийн тоо
2008 оны хичээлийн жилд	14
2009 оны хичээлийн жилд	12
2010 оны хичээлийн жилд	8
Бүгд	34

Сувилахуйн мэргэжил олгох сургалтанд хамрагдагсад

Хүснэгт

№	Мэргэжлийн чиглэл	Суралцагчдын тоо
1	Хавдрын сувилагчийн мэргэжил олгох 3 сарын сургалт	98
2	Мэс заслын сувилагчийн мэргэжил олгох 3 сарын сургалт	40
3	Эрчимт эмчилгээний сувилагчийн мэргэжил олгох 3 сарын сургалт	58
	Нийт	196

4.9. Гадаад харилцааны хөгжлийн тойм

ХСҮТ нь сүүлийн жилүүдэд гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхэд багагүй анхаарч, эрүүл мэндийн олон улсын байгууллагатай хамтран ажиллаж байна.

1995 оноос эхлэн Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-тай хамтран төслүүдийг хэрэгжүүлсээр ирсэн нь туяа эмчилгээг хөгжүүлэхэд томоохон үүргийг гүйцэтгэсээр иржээ. Өнгөрсөн хугацаанд зайн туяа эмчилгээний аппарат, төлөвлөлтийн систем, дотуур туяа эмчилгээний аппарат, цацрагийн хяналтын дозиметрийн иж бүрдэл, рентген харалт бүхий C-arm, хэлбэржүүлсэн блок цутгах төхөөрөмж зэрэг шинэ дэвшилтэт технологи тоног төхөөрөмжүүдийг суурилуулахын зэрэгцээгээр эмч, инженер мэргэжилтнүүдийг урт, богино хугацааны сургалтанд хамруулах, мэдээллээр тогтмол хангах, мэргэжилтэн зөвлөхүүдийг илгээн эмчилгээ үйлчилгээний үйл ажиллагаанд заавар зөвлөгөө, үнэлэлт өгөх зэрэг олон талт үйл ажиллагаагаар хамтран ажиллаж байна.

2009 онд Монгол Улсын Засгийн газрын урилгаар ОУАЭА-ийн Ерөнхий захирал асан Мухамед Эль-Барадэй, 2010 онд одоогийн Ерөнхий захирал Юкияа Аmano Монгол Улсад зочилж, тус байгууллагаас хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилт, туяа эмчилгээний чиглэлээр хийж буй шинэ технологи, тоног төхөөрөмжтэй танилцсан нь хамтын ажиллагаа улам гүнзгийрэх чухал алхам болсон юм.

Тухайлбал 2009 онд Монгол Улс ОУАЭА-ийн ПАКТ¹ хөтөлбөрийн наймдахь орноор сонгогдсон нь хорт хавдрын оношилгоо, эмчилгээний цаашдын хөгжилд багагүй хувь нэмрийг оруулах болно.

2009-2013 оны хугацаанд АНУ-ын Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Эрүүл мэндийн төсөлтэй халдварт бус өвчин, үүний дотор умайн хүзүү, хөхний хорт хавдраас сэргийлэх, хавдрын бүртгэлийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Олон улсын байгууллагын зэрэгцээ ХСҮТ нь дэлхийд болон бүсдээ анагаахын хөгжлөөрөө тэргүүлдэг улс орны нэр хүндтэй эмнэлгийн байгууллагатай тэргүүний туршлага солилцох, эмч, мэргэжилтнийг сургах, хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийх чиглэлээр хамтран ажиллаж байна. Тухайлбал ХСҮТ дараах байгууллагатай гарын үсэг зурсан харилцан ойлголцлын санамж бичгийн болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд үр дүнтэй ажиллаж байна.

Швейцарийн мэс заслын эмч нарын нийгэмлэг (Swiss Surgical Team). Тус нийгэмлэг ХСҮТ-ийн болон бусад эмнэлгийн мэс заслын болон мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний эмч нартай олон жилийн турш үр бүтээлтэй хамтран ажиллаж байна. Швейцарийн нэрт профессор Жиле, Жан Патрис Гарда нар ХСҮТ-ийн мэс засал, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний практик шинэ арга барилыг нэвтрүүлэхэд багагүй хувь нэмрийг оруулж байна. Үүний зэрэгцээ ХСҮТ-ийн мэс заслын олон эмч Швейцарт урт хугацааны сургалтанд хамрагдаж, мэргэжил дээшлүүлээд байна.

Япон Улсын Улаан загалмай нийгэмлэгийн эрүүл мэндийн төв (Japanese Red Cross Medical Center). Тус төвийн ерөнхийлөгч, ноён Масатоши Макүчигийн саначилгаар Японы Хитаичи-Алока, “Хариу нэхээгүй үйлс” төрийн бус байгууллагаас хамтран хандивласан хоёр ширхэг орчин үеийн Алока хэт авиан оношилгооны иж бүрдэл нь ХСҮТ-ийн оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлэхэд багагүй хувь нэмрийг оруулаад байна.

Японы анагаахын болон шүдний сүлжээ нийгэмлэг (Japanese Medical and Dental Network). Тус нийгэмлэг болон түүний захирал ноён Нагато Натсүмэгийн дэмжлэгтэйгээр жил ХСҮТ-ийн мэс заслын нэг эмчийг Япон Улсын нэр хүндтэй аль нэгэн эмнэлэгт туршлага солилцуулж, сургаж байна.

Япон Улсын Токио хотын Эмэгтэйчүдийн анагаах ухааны их сургууль (Tokio Women's Medical University Hospital). Тус их сургуультай жил бүр хамтран зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хурал уламжлал болсон төдийгүй анагаахын дэлхийд нэртэй эрдэмтэд оролцдогоороо онцлог болсон байна. Тухайлбал тус их сургуулийн профессор, японы нэрт эрдэмтэн Ямамото жил бүр, мөн 2010 оны хуралд японы дэлхийд нэртэй профессор Таказакү оролцож, манай төвийн болон

¹ Programme of Action for Cancer Therapy

бусад эмнэлгийн эмч, эрдэмтэдтэй элэгний болон ходоодны хорт хавдрын оношилгоо, эмчилгээний асуудлаар туршлага солилцсон билээ.

Тайваны үндэсний их сургуулийн эмнэлэг (Taiwan National University Hospital). Тус их сургуулийн эмнэлэг ХСҮТ-ийн мэс заслын, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, дархлал судлалын эмч, сувилагчийг элэг шилжүүлэн суулгах, дурангийн мэс заслын чиглэлээр сургаж байна.

БНСУ-ын Самсунг анагаахын төв (Samsung Medical Center). Тус төвийн ХСҮТ-ийн мэс заслын, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, дархлал судлалын эмч, сувилагчийг элэг шилжүүлэн суулгах чиглэлээр сургаад байгаа ба цаашид энэ болон хавдрын тусламж, үйлчилгээний бусад чиглэлээр ХСҮТ-тэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр тохиролцоод байна.

Солонгосын эд, эс судлалын нийгэмлэг (Korean Society of Cytopathology). Тус нийгэмлэг ХСҮТ, МЭЭСН-тэй хамтран жил бүр үндэсний хэмжээний бага хурлыг зохион байгуулж, үндэсний эд, эс судлаачдын мэргэжил дээшлүүлэхэд багагүй хувь нэмрийг оруулж байна. Үүний зэрэгцээ ХСҮТ-ийн эд, эс судлаач эмч нарыг БНСУ-д сурган, мэргэжлийг нь дээшлүүлэхэд тусалж байна.

АНУ-ын Христийн анагаахын болон шүдний холбоо (Christian Medical and Dental Association of USA). Тус нийгэмлэгийн эмч нар ХСҮТ-д жил бүр ирж, хамтран мэс засал хийхийн зэрэгцээ сургалтыг зохион байгуулдаг уламжлал тогтоод байна.

Ази-Номхон далайн орны элэгний хорт хавдрын судалгааны баг. Сингапурын Нэгдсэн эмнэлэг, хавдар судлалын төв, Азийн элэг судлалын институтийн хамтарсан энэхүү баг нь “мэс засал эмчилгээ хийх боломжгүй элэгний хожуу шатандаа илэрсэн хорт хавдрыг химийн эм болох сорафениб ба туяа эмчилгээгээр хослон эмчилж үр дүнг тооцох эмнэлзүйн туршилт” бүсийн түвшний судалгааны ажлыг ХСҮТ-тэй хамтран хийж байна.

Япон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (JICA). Тус нийгэмлэг ХСҮТ-д японы эмгэг судлаачийг сайн дурын мэргэжилтнээр ХСҮТ-д ажиллуулж, харилцан туршлага солилцуулж байна. Цаашид сувилахуйн мэргэжилтнийг ажиллуулахаар төлөвлөж байна.

БНХАУ-ын Хангжоу хотын Же Жианы их сургууль. Тус сургуулийн эмнэлэгтэй 2007 оноос хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд мэс засал, эрчимт эмчилгээ, сувилахуйн чиглэлээр туршлага солилцох, эмч нарыг суралцах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Дээрхи байгууллагын зэрэгцээ ХСҮТ нь 2011 онд БНСУ-ын Конян их сургуулийн эмнэлэг, Чоннам их сургуулийн Хвасун эмнэлэг, Эва эмэгтэйчүүдийн их сургуулийн Эмэгтэйчүүдийн хавдар судлалын төв (Итгэл-хавдаргүй Монгол сантай гурвалсан) –тэй харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагааг бий болгох эхлэлийг тавиад байна.

